

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Дашзэвэг	Дугаар	L099
Оршин суугаа аймаг	Хэнтий	Оршин суугаа сум	Жаргалтхаан сум
Төрсөн газар	Жаргалтхаан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Гичгиний хурал	Сүм хийдийн дугаар	ХЭЖХ 011
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 18	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Гичгиний хурал

-Та өөрийн нутаг орондоо байсан хийдийн тухай мэдэх , сонссон дуулсан зүйлээ хэлж өгөөч?

Юм мэдэхгүй ээ жаахан 8 настай байсан. Цамд нэг очиж байсан. Олон лам байдаг байсан. Би бол мэдэхгүй ээ.

-Уртын шүтээн, Мэргэн хамбын хурлын тухай мэдэх үү?

Мэдэхгүй.

-Уугийн хурал?

Юу ч мэдэхгүй. Харин Гичгиний хурал том хурал байсан.

-Гичгиний хурал хэр олон ламтай хурал байсан юм болоо?

Олон байсан. Сүүлдээ хөгшин лам нар нь баригдаад явчихсан. Залуучууд нь энүүгээр байсан байх. Олон ламтай байсан даа.

-Хэр олон дугантай байсан бэ?

Гэр дуган гэж нэг юм байсан. Том дуган байсан. Хэдэн байшин дуган байсан байхаа.

-Олон суварга энэ тэр байсан болов үү?

Мэдэхгүй. Би Гичгинийх.

-Гомбожав гуай мэдэх болов үү?

Мэднэ. Бүр тэр үед манз, цав зөөдөг байсан юм. Өндөр домбо шиг юмаа даахгүй хүүхэд л явдаг байсан. Жаахан байсан юм. Одоо 80 гарч байгаа. Яг Гичгиний юуг бол сайн мэднэ дээ.

-Энд байсан Улаан худгийн хийдийг байсан л гээд байх юм. Мэдэх хүн байхгүй л байх юм.

Хийд байсан л юм байх даа.

-Тунбаа гуай намайг бага байхад байсан гээд байгаа юм даа.

Осоржам бол мэднэ дээ.

Одоо энэ Цогоогийн ээж

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Магадгүй ээ. Энэ баруун урдуур байдаг байсан юм.

-Тэгээд энэ Гичгиний хурал хэдэн онд нураагдсан юм бол?

Оныг нь би мэдэхгүй. Тун амархан нураасан даа. Лам нар нь баригдаад. Ном аваачаад дүүргэчихсэн амбаар байсан. Тэгээд амьтан хүн ирээд хоргой энэ тэрийг нь аваад явчихсан байна лээ. Би бас авч байсан. Хувийн байшин их байсан. Суурин газар байсан. Гэр дуган гэж барьдаг байсан тэрийг хүмүүс аваад. Гомбожав гуай сайн мэднэ. Хамаг юмыг нь булахыг нь булаад. Дүүрэн бурхан ном байсныг үгүй хийсэн. Тэгээд байшин нь нураад цагаан тараг шиг л юм болсон. Байшин дуган байдаг байсан байхаа.

-Энд өөр онцлох хурал болдог байсан уу? Хайлан тэгээд Майдар эргэх гэх мэт.

Үгүй байхаа. Лам нар чинь дором хийх гээд, нэг гоё гурил хийдэг байсан.

-Тахилын хийдийг мэдэх хүн байгаа болов уу?

Энэ зүүн хойд талынхан мэднээ.

-Таны сонссон юм байгаа юу?

Үгүй үгүй. Улаан худгийн талаар та нар Осоржамтай таарвал асуугаарай. Тун жаахан байсан байхаа. Өөр Цэрэндорж гуай мэдэхгүй байна уу?

-Сайн мэдэхгүй байна лээ. Их л эртний хийд гэж байна л даа.

Мэдэхгүй. Зүүн хойд уулын энгэрт Хүүхэн хутагтын хүрээ рүү цам гарахаар явдаг байсан. Их сайхан байсан юм. Цорж нар ихтэй.

-Гичгиний хурал дээр бас Майдар энэ тэр эргэдэг л байсан байх даа?

Мэдэхгүй. Майдар гэж юм ярьж байгаагүй дээ.

-Гичгиний хурлыг Баатарын дацангаас тасарсан хурал гэсэн.

Мэдэхгүй. Их л дээр үеийн хурал юм шиг байгаа юм.

-Багцаагаар хэдэн оны үеийн хурал юм бол?

Би яаж мэдэхэв.

-Баатарын дацангаас тасарсан бол нэлээд сүүлд л баймаар юм?

Сүүлд ч байгаагүй болов уу даа.

-Та Гүржсоном гэдэг хүнийг дуулаа биздээ?

Тэр чинь харин тэгсэн гэж яриа байдаг. Нэлээн дээр байсан байх. Би одоо худлаа ярьж мэднэ дээ. Гичгиний хурлын байшин 30 хүрвэл энэ хурал баларна. Тэр Гичгиний ус урсдаг юм. Зүүн урагшаа урсвал Гичгинийхэн хоосорноо гэсэн гэнэ лээ. Сүүлдээ зүүн урагш татарсан гэнэ лээ. Гичгиний байшин 30 хүрсэн гэнэ лээ. Манай ижий ярьж байсан. Би тоодог ч үгүй байж дээ. Тэгээд 30 хүрсэн нь үнэн шүү айхтар мэддэг хүн байсан шүү гэж байсан.

-Энэ Гичгинийг байгуулсан хүн нь тэгж хэлсэн юм уу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гүржсоном гэж айхтар шинжээч хүн байсан юм гэнэ лээ. Тэр л тэгж хэлсэн гэсэн. Тэрийг танай ажаа энэ тэр мэдэж л байгаа. Энэ тэндэхийн уул усыг сайн шинждэг хүн байсан. Нүүрэнтгийг бол сайн шинжсэн гэсэн. Эхэн усны усыг бол гүехэн цоолчихвол далай болно энэ тэр гэж ярьсан гэдэг.

Тэгсэн хурлаас нэг хүүхдээ дагуулсан хүн цамд явжээ. Тэгээд еэ бас энийг зосгоох юмсан. Явуулж болохгүй гээд байсан. Нөгөөдүүл нь энэ нэг юм одоо зөнөглөөд хүн амьтан ч явуулахаа болилоо гэж одож байсан. Энэ зовж ганцаараа ирнээ гэсэн гэдэг. Тэгээд цамд очоод жаалаа алдчихаад ирсэн юм гэнэ лээ гэж манай ижий ярьж байсан юм. Тийм айхтар хүн байсан юм. Тэрийг мэдэх хүн одоо байвал 100 гаран насны хүн байх ёстой. Би ижийгийн ярьж байсныг сонссон.

-Гичгиний хийдийн хамба лам нь тийм хүн байсан гэнэ лээ, тийм хүн байгуулсан юм гэнэ лээ гээд дуулсан юм байна уу ?

Би мэдэхгүй. Хурал байхад хамба лам нь хэн байсан юм бол доо. Баригдаад л явцгаасан даа.

-Тэр үед олон лам гэж хэдэн ламаа хэлдэг байсан юм, цөөн лам гэж хэдэн ламаа хэлдэг байсан юм бол?

Гичгинд нэлээн олон хүн байдаг байсан. Өвөл хаагддаг байсан. Битүүнд Цэдэр хурна гээд лам нар нь явдаг байсан.

-Хойд талын тахидаг уулыг юу гэдэг билээ?

Баян уулыг тахина. Готовыг тахина, Баян хааныг тахина. Тэгээд 3 уул тахидаг байсан. Нүүрэнтгийг тахина.

-Жамъянсүрэн гуай хэр их мэдэх бол?

Дуулсан юм их. Нэг сайн ламын удам байсан юм гэнэ лээ.

-Тэгээд Цэдэрээ хурчихаад 15-ны ерөөл энэ тэр гэж хурдаг байсан уу?

Мэдэхгүй, би тэрийг мэдэхгүй. Ямар ч байсан битүүнд явдаг байсан. Настай лам нар ч их явдаг байсан.

-Ер нь зун намартаа л хурдаг байсан уу?

Намар нь ер нь тэгээд хаачихдаг болтой байсан. Ер нь зундаа л хурдаг байсан байх. Өвөл нэг жилтний хурал хийдэг байсан.

-Тэгэхээр тэр чинь аягүй бол 15-ны ерөөл байх. Цэдэрээс хойш 15 хоног шинийн нэгэн гээд л байгаа?

Аягүй бол тийм байхаа. Жилтний хурал гээд боов хийнэ гээд тэдний боовноос илүүг хийнэ, тэдний боовноос илүүг иднэ гээд. Хаврын эхэн сард. Манай нэг хамаатны лам байсан юм тэднийд боов л идэх гэж очдог байсан.

Би тэр үед бүрхан Гончигсумлаа хэрэгтэй гэж мэддэггүй байлаа. Хүүхэд байсан юм чинь.

-Тухайн үед Гичгэний хурлын сайн лам нар нь ямар хүмүүс байв?

Олон лам нарыг онцгойлоод сайн гэдэг байсан. Би одоо аль нь сайн аль нь мууг мэдэхгүй. Айхтар хувилгаан хутагт байхгүй. Уугийн хурал гэж байсан л юм гэнэ лээ. Би тэрийг сайн мэдэхгүй.

- Гичгэний хийдийг мэдэх хүн хэн байна? Мэдэж магадгүй гэсэн хүнийг та хэл дээ?

Одоо мэдэхгүй. Бараг байхгүй байх.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА